



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ДАРХАН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/35/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Ч.Болормаа

Утас: 70373089 Цахим хаяг: bolormaach@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	17
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 52

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, Боловсролын яам, GIZ хамтран санхүүжүүлж буй "Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт-II" төслийн хүрээнд хүлээн авсан 23,407.6 мянган төгрөгийн материал, сургалтын хэрэгслийг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Тус коллежийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 27 дугаар тогтоолын 2.2 дахь заалтын дагуу Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж, Дархан Өргөө политехник коллеж, Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийг нэгтгэж, Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллеж болгон өөрчлөн зохион байгуулснаар төсөвт зардлын гүйцэтгэл 9,534,763.2 мянган төгрөг болж 89.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан политехник коллежийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 73 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.1 хувиар үнэлэн дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

4525020177

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	3,864,135,871.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,156,518,774.94
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,156,518,774.94
3121	Төгрөг	-	1,156,518,774.94
31211	Төрийн сангийн харилцах	-	1,156,518,774.94
35	БАРАА МАТЕРИАЛ	-	2,707,617,096.49
351	Түүхий эд материал	-	162,393,546.22
35110	Тусгай зориулалттай материал	-	159,000,003.22
35130	Эм боох материал	-	3,393,543.00
354	Хангамжийн материал	-	2,545,223,550.27
35410	Бичиг хэргийн материал	-	13,075,500.00
35420	Аж ахуйн материал	-	782,818,246.58
35430	Сэлбэг хэрэгсэл	-	33,859,400.00
35440	Түлш, шатах тослох материал	-	9,340,000.00
35450	Барилгын засварын материал	-	199,018,640.22
35460	Хүнсний материал	-	16,625,750.00
35470	Бусад хангамжийн материал	-	1,490,486,013.47
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	27,928,849,377.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	27,928,849,377.02
392	Биет хөрөнгө	-	22,784,083,027.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	23,872,905,851.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,073,289,468.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	1,456,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(731,259,061.99)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	2,972,228,511.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,463,150,923.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	465,631,317.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(225,611,718.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	149,396,500.72
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(61,447,355.97)
39217	Ном	-	422,279,374.73
393	Биет бус хөрөнгө	-	5,144,766,349.67
39301	Програм хангамж	-	26,021,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(21,414,650.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	5,140,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	31,792,985,248.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	31,792,985,248.45
51	Засгийн газрын хувь оролцоо	-	31,792,985,248.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	15,515,229,213.92
51101	Өмч: - төрийн	-	15,515,229,213.92
512	Хуримтлагдсан үр дүн	-	(2,494,620,714.51)
51210	Өмнөх үеийн үр дүн	-	(34,287,605,962.96)
51220	Тайлант үеийн үр дүн	-	31,792,985,248.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	18,772,376,749.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	31,792,985,248.45



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	42,827,709,052.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	31,742,083,552.53
120	Нийтлэг татварын бус орлого	-	31,742,083,552.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	73,785,567.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	45,148,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	28,637,567.50
120009	Бусад орлого	-	90,369,910.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		29,356,431,916.07
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		2,221,496,158.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	11,085,625,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	10,540,625,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	10,540,625,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	545,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	545,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	11,034,723,804.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	11,034,723,804.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	10,397,693,650.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	6,248,008,751.00
210101	Үндсэн цалин	-	3,731,401,130.81
210102	Нэмэгдэл	-	1,800,108,280.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	379,643,322.00
210104	Урамшуулал	-	336,856,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	773,133,316.31
210201	Тэтгэврийн даатгал	-	530,709,953.41
210202	Тэтгэмжийн даатгал	-	62,264,622.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	30,807,391.66
210204	Ажилгүйдлийн даатгал	-	29,772,198.69
210205	Эрүүл мэндийн даатгал	-	119,579,150.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	500,598,961.37
210301	Гэрэл, цахилгаан	-	131,499,840.95
210302	Түлш, халаалт	-	259,129,783.47
210303	Цэвэр, бохир ус	-	109,969,336.95
2104	Хангамж, бараа материалын зардал	-	182,864,946.15
210401	Бичиг хэрэг	-	10,528,850.00
210402	Тээвэр, шатахуун	-	13,459,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	4,099,302.62



210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,589,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	36,401,342.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,557,600.00
210408	Бараа материал акталсны зардал	-	113,229,301.53
2105	Нормативт зардал	-	434,541,666.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	4,217,317.00
210502	Хоол, хүнс	-	430,324,349.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	34,065,183.97
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	11,719,500.00
210604	Урсгал засвар	-	22,345,683.97
2107	Томилолт, зочны зардал	-	3,209,900.00
210702	Дотоод албан томилолт	-	3,209,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	152,545,411.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	151,022,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	423,411.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,068,725,514.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	228,069,803.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	322,519,021.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	1,518,136,689.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	637,030,153.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	635,505,985.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	261,915,985.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	369,890,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,524,168.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,524,168.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	31,792,985,248.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	31,792,985,248.45



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	11,249,780,977.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	164,155,477.50
120	Нийтлэг татварын бус орлого	-	164,155,477.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	97,255,477.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	45,148,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	28,637,567.50
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	23,469,910.00
120009	Бусад орлого	-	66,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	11,085,625,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	10,540,625,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	10,540,625,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	545,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	545,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	10,002,708,052.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	10,002,708,052.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	9,365,677,898.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	6,248,008,751.00
210101	Үндсэн цалин	-	3,731,401,130.81
210102	Нэмэгдэл	-	1,800,108,280.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	379,643,322.00
210104	Урамшуулал	-	336,856,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	773,133,316.31
210201	Тэтгэврийн даатгал	-	530,709,953.41
210202	Тэтгэмжийн даатгал	-	62,264,622.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	30,807,391.66
210204	Ажилгүйдлийн даатгал	-	29,772,198.69
210205	Эрүүл мэндийн даатгал	-	119,579,150.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	500,598,961.37
210301	Гэрэл, цахилгаан	-	131,499,840.95
210302	Түлш, халаалт	-	259,129,783.47
210303	Цэвэр, бохир ус	-	109,969,336.95
2105	Нормативт зардал	-	407,518,223.00
210502	Хоол, хүнс	-	407,518,223.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	136,307,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	93,430,830.00
210604	Урсгал засвар	-	42,876,870.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	167,681,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	167,681,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,132,429,447.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	624,699,491.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	507,729,956.00



213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	637,030,153.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	635,505,985.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	261,915,985.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	369,890,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,524,168.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,524,168.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,247,072,924.94
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	90,554,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	90,554,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	90,554,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	90,554,150.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(90,554,150.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,156,518,774.94
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,156,518,774.94



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	15,515,229,213.92	18,772,376,749.04	(34,287,605,962.96)	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,515,229,213.92	18,772,376,749.04	(34,287,605,962.96)	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	31,792,985,248.45	31,792,985,248.45
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,515,229,213.92	18,772,376,749.04	(2,494,620,714.51)	31,792,985,248.45




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,612,763,200.00	9,534,763,152.56	(1,078,000,047.44)	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,612,763,200.00	9,534,763,152.56	(1,078,000,047.44)	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,612,763,200.00	9,534,763,152.56	(1,078,000,047.44)	89.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,693,758,700.00	6,248,008,751.00	(445,749,949.00)	93.3
210101	Үндсэн цалин	4,376,710,400.00	3,731,401,130.81	(645,309,269.19)	85.3
210102	Нэмэгдэл	1,948,829,200.00	1,800,108,280.19	(148,720,919.81)	92.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	368,219,100.00	379,643,322.00	11,424,222.00	103.1
210104	Урамшуулал	-	336,856,018.00	336,856,018.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	836,719,900.00	773,133,316.31	(63,586,583.69)	92.4
210201	Тэтгэврийн даатгал	568,969,500.00	530,709,953.41	(38,259,546.59)	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	66,937,600.00	62,264,622.46	(4,672,977.54)	93.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,468,800.00	30,807,391.66	(2,661,408.34)	92.0
210204	Ажилгүйдлийн даатгал	33,468,800.00	29,772,198.69	(3,696,601.31)	89.0
210205	Эрүүл мэндийн даатгал	133,875,200.00	119,579,150.09	(14,296,049.91)	89.3
2105	Нормативт зардал	539,411,500.00	407,518,223.00	(131,893,277.00)	75.5
210502	Хоол, хүнс	539,411,500.00	407,518,223.00	(131,893,277.00)	75.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	162,913,800.00	160,081,230.00	(2,832,570.00)	98.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,779,200.00	58,970,900.00	(2,808,300.00)	95.5
210602	Тавилга	7,679,500.00	7,679,500.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	93,455,100.00	93,430,830.00	(24,270.00)	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,400,000.00	167,681,500.00	(2,718,500.00)	98.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,400,000.00	167,681,500.00	(2,718,500.00)	98.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,472,340,500.00	1,143,034,147.25	(329,306,352.75)	77.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	638,173,500.00	634,504,191.25	(3,669,308.75)	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	834,167,000.00	508,529,956.00	(325,637,044.00)	61.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	737,218,800.00	635,305,985.00	(101,912,815.00)	86.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	737,218,800.00	635,305,985.00	(101,912,815.00)	86.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	266,610,800.00	261,915,985.00	(4,694,815.00)	98.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	467,108,000.00	369,890,000.00	(97,218,000.00)	79.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,612,763,200.00	10,614,411,067.50	1,647,867.50	-
21	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,540,625,500.00	10,540,625,500.00	-	-
210	Улсын төсвөөс санхүүжих	10,540,625,500.00	10,540,625,500.00	-	-
2101	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	72,137,700.00	73,785,567.50	1,647,867.50	-
210101	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,666,900.00	45,148,000.00	(5,518,900.00)	-
210102	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,470,800.00	28,637,567.50	7,166,767.50	-
210103	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,079,647,914.94	1,079,647,914.94	-
210104	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
2102	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
210201	АЖИЛЛАГСДЫН ТОО	243.00	240.00	(3.00)	98.8


210202	Удирдах ажилтан	9.00	6.00	(3.00)	66.7
210203	Гүйцэтгэх ажилтан	165.00	165.00	-	100.0
210204	Үйлчлэх ажилтан	69.00	69.00	-	100.0
210205	Төрийн өмчит МСҮТ	1.00	1.00	-	100.0
2105	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	243.00	240.00	(3.00)	98.8
210502	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3.00	3.00	-	100.0
210503	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	168.00	165.00	(3.00)	98.2
2106	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	3.00	3.00	-	100.0
210601	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	69.00	6.00	(63.00)	8.7



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	543,475,831.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	543,475,831.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,475,831.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	500,598,961.37
210301	Гэрэл, цахилгаан	131,499,840.95
210302	Түлш, халаалт	259,129,783.47
210303	Цэвэр, бохир ус	109,969,336.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,876,870.00
210604	Урсгал засвар	42,876,870.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	543,475,831.37
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	543,475,831.37
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	543,475,831.37
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I) <small>ХТ0543022072899</small>	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан политехник коллеж нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсролын яамны харьяа байгууллага юм.

Дархан политехник коллеж нь “Ёс зүйг эрхэмлэсэн, хөрвөх, өрсөлдөх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/103 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Боловсролын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан политехник коллеж нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан политехник коллеж нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 3 коллежийг нэгтгэж, Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллеж болгон зохион байгуулсан тул оны эхний үлдэгдэл тайлагнагдаагүй болно.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,156,518.7	1,156,518.7
Авлага	-	-	-
Бараа материал	-	2,707,617.0	2,707,617.0
Үндсэн хөрөнгө	-	27,928,849.3	27,928,849.3
Нийт хөрөнгө	-	31,792,985.2	31,792,985.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	31,792,985.2	31,792,985.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	31,792,985.2	31,792,985.2

Гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнээр улсын төсвийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй бөгөөд санхүүжилтээс зарцуулагдаагүй үлдэгдэл 1,079.6 сая төгрөг, ахмадын сангийн 100190015500 дансны үлдэгдэл 76.9 сая төгрөгийг мөнгөн хөрөнгө дансанд тайлагнасан байна.

Тайлант онд 1,466,286.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 2,168,088.6 мянган төгрөгийн материал бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан, 30,000.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авсан, сургуулийн үйл ажиллагаанд 980,165.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан зэргээс шалтгаалж оны эцэст 2,707,617.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд бусад хангамжийн материал буюу бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, сургалтын хэрэглэгдэхүүнүүд 55.0 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 27,928,849.3 мянган төгрөгийн үлдэгдэл бүртгэсэн нь бүтцийн өөрчлөлтөөр 36,222,961.9 мянган төгрөгийн хөрөнгө, 399,514.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 90,554.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 211,813.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,997,993.9 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэн, тайлант хугацааны 1,518,136.7 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 31,792,985.2 төгрөг нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,054,942.2 мянган төгрөгөөр улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг тайлант жилийн эхэнд 230,482.3 мянган төгрөгөөр бууруулж, 10,824,459.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тайлант онд багш, ажилтнуудын шилжилт хөдөлгөөн хийгдсэн, тэтгэвэрт гарах, ажлаас чөлөөлөгдөх үүнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн хэмнэлт үүссэн байна. Мөн дотуур байрны сурагчдын тоо төсөвлөсөн тоонд хүрээгүй учраас хоолны зардлын хэмнэлт үүссэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 зорилтын 73 арга хэмжээнд зарцуулах 11,389,211.8 мянган төгрөгийн санхүүжилтэд 776,448.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,540,625.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 72,137.7 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,540,625.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 73,785.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс 9,534,763.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс 545,000,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 543,475.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилтийн 1,524.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71804-Мэргэжлийн боловсрол	11,389,211.8	10,078,239.0	1,310,972.8	88.5%
1.1	81834 -Боловсролын стандарт,сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	8,598,283.3	7,761,356.2	836,927.1	90.3%
1.2	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	495,311.9	495,159.2	152.7	100.0%
1.3	80219- Харуул хамгаалалтын зардал	170,400.0	167,681.5	2,718.5	98.4%
1.4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	737,218.8	635,306.0	101,912.8	86.2%
1.5	81806-Дотуур байрны үйлчилгээ	539,411.5	407,518.2	131,893.3	75.5%
1.6	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	776,448.6	543,475.8	232,972.8	70.0%
1.7	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	72,137.7	67,742.0	4,395.7	93.9%
Нийт дүн		11,389,211.8	10,078,239.0	1,310,972.8	88.5%

Нэгдсэн судалгааны дүнгээр тус коллеж нь 243 орон тоо баталснаас гүйцэтгэлээр 240 албан хаагч ажилласан.

Тайланд онд ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сан байгуулсан.

Батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 151,022.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 646,711.6 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтээр байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 500,598.9 мянган төгрөг, 131,499.8 мянган төгрөгийн гэрэл цахилгаан, 259,129.8 мянган төгрөгийн түлш халаалт, 109,969.3 мянган төгрөгийн цэвэр бохир ус, 42,876.8 мянган төгрөгийн урсгал засварт зарцуулжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, Боловсролын яам, GIZ хамтран санхүүжүүлж буй “ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ-II” төслийн хүрээнд 23,407.6 мянган төгрөгийн материал, сургалтын хэрэгсэл нийлүүлэгдсэн. Техникийн болон мэргэжлийн боловсролын тогтолцооны шинэчлэлийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг эхлүүлэхэд дэмжих үндсэн зорилго, төлөвлөгөөтэй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны хүрээнд нийт 6 эдийн засгийн ангиллаар 20 багцын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж, 155,697.8 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт зарлан, 2 байгууллагатай гэрээ байгуулж, 101,189.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, цахим дэлгүүрээс 4,488.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Ч.Болормаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 10,540,625.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 105,406.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нэгтгэсэн 3 коллежид илэрсэн дараах зөрчлийн хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Дархан-Уул аймаг дахь Политехник коллежид 1 зөвлөмж,
- Дархан өргөө политехник коллежид илэрсэн 25,858.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж,
- Уул уурхай, эрчим хүчний политехник коллежид илэрсэн 3,295.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт зэрэг аудитын шийдвэрийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	25,858.8	2	25,858.8	100.0
Төлбөрийн акт	2	3,295.6	2	3,295.6	100.0
Албан шаардлага	-	-	-	-	100.0
Нийт дүн	4	29.154.4	4	29.154.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,737.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 58,970.9 мянган төгрөгийн багаж техник хэрэгсэл, 7,679.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 дахь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

заалт “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, УСНББОУС 24 “Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн тодруулга”, санхүүгийн тайлагналын “Иж бүрэн байх”, “Толилуулга”, “Тохиолдсон байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул дээрх зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд толилуулж залруулав.

Мөн аудитаар нийт 7,087.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Тайлант онд нягтлан бодогч, нярав нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалттай давхардуулан 7,087.1 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.9-д “Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэж заасантай тус тус нийцээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
									Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд багаж техник хэрэгслийн зардал 61.779.200.00 төгрөг, тавилга 7.679.500.00 төгрөгийн зардлыг тайлагнаагүй.	1	66,650.4	1	66,650.4			1	66,650.4						
Дүн	1	66,650.4	1	66,650.4	1	66,650.4	1	66,650.4						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд нягтлан бодогчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалттай давхардуулан 7.087.127.00 төгрөгийн балансын урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.	1	7,087.1			1	7,087.1						
Дүн	1	7,087.1			1	7,087.1						